# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 17-ны өдөр Дугаар БА-055/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-уул дүүргийн 10 дугаар хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын зоорьтой 5 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 19 (арван ес) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/10/17 огноо, 0001449, БА32024/0703 зөвшөөрлийн дугаар,

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: Е.Г.Шифр:GOS-02/22,

2.3. Захиалагч: Иргэн Боржигин овог, Дашням эцэг эхийн нэр, Хулан өөрийн нэр, УУ82122101 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 19 дүгээр хороо, 72а-30 тоот, 99028779 холбоо барих утас;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Сити гласс ХХК оноосон нэр, 000179385 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6398162 регистрийн дугаар, БУ17-992/19 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4 дугаар хороо, Биг барилгын материалын худалдааны төв В блок, 99088779 холбоо барих утас, E-mail: info@cityglass.mn цахим хаяг;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Дэхан ХХК оноосон нэр, 9011279062 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5464579 регистрийн дугаар, БУ17-691/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 11 дүгээр хороо, мандалын гудамж, 08-211 тоот 99088206 холбоо барих утас

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Ориент плюс ХХК оноосон нэр, 9011078092 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5087074 регистрийн дугаар, ЗТ19-147/21 Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их тойруу-17, Одкон холдинг ХХК-ийн байр, 311 тоот 80001002 холбоо барих утас

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Иргэн Боржигин овог, Дашням эцэг эхийн нэр, Хулан өөрийн нэр, УУ82122101 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг 19 дүгээр хороо, 72а-30 тоот, 99028779 холбоо барих утас;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ бага төвөгшилтэй ангиллын зоорьтой 5 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 19 (арван ес) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

ХЯНАЛТ ШАЛ
ГАЗА
Барилга байгууламжи
оруулах ко

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Бага төвөгшилтэй ангиллын зоорьтой 5 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 19 (арван ес) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжид ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-уул дүүргийн 10 дугаар хороо, Иргэн Д.Хулангийн захиалгатай, зоорьтой 5 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 19 (арван ес) айлын орон сууцны барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
Бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

9024041846
8314551 СБТ24866

Нарийн бичгийн дарга:
Захиалагч Иргэн (Д.Хулан)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объектын дугаар: 687
Огноо: 2025 он 02 сар 17 өдөр
Бүртгэсэн: О. Жигэр
УЛААНБААТАР ХОТ ТТМ 21584

...АЛТЫН
...г ашиглалтанд
...исс

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРОО, ИРГЭН Д.ХУЛАНГИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 5 ДАВХАР 1 БЛОК, 7 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ, 19 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 13 — Улаанбаатар хот

Хан-уул дүүргийн 10 дугаар хороо, Иргэн Д.Хулангийн захиалгатай, зоорьтой 5 давхар 1 блок, 7 автомашины дулаан зогсоолтой, 19 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхарт 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр 11:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 13:00 цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Хуралд:

| | | |
|---|---|---|
| 1 | Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2 | Хяналт шалгалтын газар Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Н.Ёндонсамбуу |
| 3 | Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 4 | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, ХҮТ-18-н инженер | З.Ганхуяг |
| 5 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техникийн хяналтын инженер | Ц.Билигт |
| 6 | Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн | Н.Болор-Эрдэнэ |
| 7 | Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Д.Болормаа |
| 8 | Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК ШХХА-ны инженер | Ж.Биндэрьяа |
| 9 | Нийслэлийн онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын тасаг, хошууч | Б.Даваасүрэн |
| 10 | Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Э.Шижиртуяа |
| 11 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч | Б.Ганзориг |
| 12 | Зураг төслийн Ориент плюс ХХК-ийн архитектор | Б.Мөнхэрдэнэ |
| 13 | Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер | Г.Уртнасан |
| 14 | Гүйцэтгэгч Сити гласс ХХК-ийн захирал | Б.Алтансайхан |
| 15 | Захиалагч Иргэн | Д.Хулан |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-уул дүүргийн 10 дугаар хороо, Иргэн Д.Хулангийн захиалгатай, зоорьтой 5 давхар 1 блок, 7 автомашины дулаан зогсоолтой, 19 айлын орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Н.Ёндонсамбуу:**

- Барилгын тухай хуулийн дагуу гүйцэтгэгч байгууллага баталгаа албан тоот ирүүлэх;
- Өөрчлөлтийн зураг хийлгэж баталгаажуулах;
- Бетоны лабораторын шинжилгээ нөхөж үзүүлэх 1% өгөх;
- Нийтийн эзэмшлийн цонхонд хязгаарлагч хийх;
- Айл өрхүүдийн хаалга мөргөлдөж буйд тайлбар албан тоот өгөх, шийдвэрлэх;
- Техникийн давхарт айл өрх амьдруулахгүй баталгаа албан тоот өгөх;
- Усны хаялага доош гүйцээж буулгах;
- Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээтэй зориулалтаар ашиглах баталгаа албан тоот ирүүлэх;
- Гадна фасадны силикон шахаж дуусгах;
- Айл өрхүүдийн тоог тодорхой болгох;
- Гүйцэтгэгч компани тусгай зөвшөөрөл сунгуулсан эсэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Орон сууц нийтийн удирдах аж ахуйн удирдах газар, ХҮТ-18 инженер **З.Ганхуяг**

- Гадна шугам сүлжээ зургийн дагуу стандарт хэмжээнд хийгдсэн;
- Узель болон цахилгааны өрөөнд цэвэрлэгээ хийх, техникийн өрөөг суллах ;
- Узелийн дуу чимээг намсгах арга хэмжээ авах, тусгаарлагч хийх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, техникийн хяналтын инженер **Ц.Билигт:**

- Аянгын хүрээг зургийн дагуу гүйцэтгэх
- Цахилгааны өрөөний хаалгыг галд тэсвэртэй хаалгаар солих, хаяг хийх
- Цахилгааны өрөөнд хураасан эд хогшил гаргах
- Цахилгааны самбарт схем хийх
- Цахилгааны самбар узелийн тоног төхөөрөмжийн хүрээг газардуулгаар холбох
- Газардуулгын утсанд хамгаалалт хийх төгсгөвч
- В1 давхар цахилгааны өрөө самбарын гүйцэтгэлийн зураг

- Шинэ хэрэглэгчийн сүлжээнд залгах зөвшөөрлийн бичиг
- Гадна цахилгаан хангамжийн ажлын зураг, бичиг баримт үзүүлэх
- Тоолуур солих

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ:**

- Айлуудын домофон суурилуулан хэвийн ажиллагаанд оруулах;
- Камерийн хяналтын төхөөрөмжүүдийг зурагт тусгагдсан цоожтой ракан‌д суурилуулах, бичлэг доод тал нь 1 сар хадгалдаг байх;
- Ил далд ажлын актуудыг дахин үйлдэх, засварлах;
- Зоорийн давхрын өөрчлөлтийн зураг шалгуулах;
- Техникийн нөхцлийн хугацаа дууссан сунгуулах
- Гадна холбооны угсралт хийгдээгүй тул санал өгөх боломжгүй байна.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Д.Болормаа:**

- Холбогдох бичиг баримт бүрдүүлж гэрээ байгуулах;
- Нийслэлийн эрүүл мэндийн газарт ундны усны шинжилгээ өгч дүгнэлт гаргуулах
- Цэвэр усны холболттой худгийг стандартын дагуу угсрах тоосгоор өрсөн хүзүүвчийг солих
- ОСНААУГ-с олгосон 17/2022 тоот техникийн тодруулгын хэрэгжилт хангагдсан тухай албан баталгаа бичгийг холбогдох байгууллагаас авах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, ШХХА-ны инженер **Ж.Биндэръяа:**

- Батлагдсан зураг төслийн дагуу гадна шугамын худаг янзлах
- Узелийн өрөөнд ус буулгах трап хийх
- Узелийн өрөөний тоноглолын тоос шороо цэвэрлэж хаягжуулалт хийх
- Дотор системийн халаах хэрэгслүүдэд термостат суурилуулах
- Гүйцэтгэлийг фото зургаар баталгаажуулж үзүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч хошууч **Б.Даваасүрэн**:

- БА, ЦБУ тэмдэг дарсан зураг үзүүлэх
- Техникийн давхар айл сууцаар ашиглахгүй
- Галын дохиоллын систем батлагдсан зургийн дагуу хийгдээгүй, шалгасан акт фото зураг
- ГК хошууг солих, ус тавьж шалгах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах
- Авто зогсоол тэмдэг тэмдэглэгээ байрлуулах
- Зоорь 1-р давхар зураг өөрчилсөн өөрчлөлтийн зураг байхгүй

ХЯНАЛТ

арилга байгу
ору

- Айлаас гарах хаалга зургаас зөрсөн
- Үүдний хэсэг зургийн дагуу хийх
- Цахилгаан щит дохиоллын систем төлөвлөх гал унтраах автомат бие даасан систем төлөвлөх
- Эд хогшил цэвэрлэх, металл хаалга хийх
- Дээврийн ус зайлуулах хоолой гүйцээж хийх

Татгалзах саналтай байна.

Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх, баталгаажуулах
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага баталгаа гаргах
- Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдүүлэх
- Бүх баримтын хуудас дугаарлаж, дотоод товъёг үйлдэх
- Ажлын зураг болон холбогдох баримтийн их хувийг архивт хүлээлгэн өгөх

Үүрэг даалгавараар ашиглатанд оруулах саналтай.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна оггтолгооны худаг батлаглсан зургийн дагуу хийх
- Узелийн өрөөнд ус зайлуулах трап, хаягжуулалт хийх
- Халаах хэрэгсэлд термостат хийх
- Гадна шугам мэдээллийн санд оруулах /цэвэр бохир халаалт/
- Дээвэр дээрхи үнэр гаргагч дулаалах, дефлентернээс дээш өндөрлөх, таг хийх
- НЭМГ-н байцаагчаар ундны усны дүгнэлт гаргуулах
- Гадна дотор шугам сүлжээ угсарсан ААН-н тусгай зөвшөөрөл шалгуулах
- Шугам сүлжээний ашиглалтыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д хариуцуулах
- Узелийн дуу чимээг багасгаж айлуудад сонсогдохгүй болгох

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч **Б.Ганзориг:**

- Гадна авто зогсоол явган хүний замын тэмдэг тэмдэглэгээ байхгүй байна
- В1 авто зогсоол аюулгүй байдлын стандарт шаардлагад нийцээгүй
- Орц хэсгийн налуу зам шат аюулгүй байдалд нийцээгүй

Уг барилгыг ашиглалтанд авахыг татгалзаж байна.

Зураг төслийн Ориент плюс ХХК-ийн архитектор **Б.Мөнхэрдэнэ:**

- Гадна гонхны дулаан тусгаарлах хаалгыг хийх

Гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

ШАЛГ
АЗАР
амжи
лах ко

Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **Г.Уртнасан:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан нормачлалын сангийн төлбөр төлөх
- Пандусанд гулсалтаас хамгаалсан гадаргуу хийх
- Зоорийн давхар 1-р давхрын өөрчлөлтийн зураг төслийг баталгаажуулах
- Техникийн давхрын өрөөнүүдийг норм дүрмийн дагуу зориулалтын дагуу ашиглах
- Дээврийн ус зайлуулах хоолойг гүйцээж хийх
- Дээврийн дутуу ажлыг гүйцээх
- Тагтанд хамгаалалт хийх
- ХБИ замыг зураг төслийн дагуу гүйцэтгэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Гүйцэтгэгч Сити гласс ХХК-ийн захирал **Б.Алтансайхан:**

- Үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Захиалагч Иргэн **Д.Хулан:**

- Үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих;
- БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа албан тоотоор ирүүлэх
- Дээврийн заслын ажлыг бүрэн дуусгах, үүнд металл фасад дутууг гүйцээх, усны хоолой доош буулгах, тоосго буулгаж чөлөөлөх, өнгө засал
- Техникийн давхар зориулалтын дагуу ашиглах баталгаа албан тоот ирүүлэх
- Тагтны шилэн хаалтанд металл хамгаалалт нормын дагуу гүйцэтгэх
- Айл өрхүүдийн гадна хаалга мөргөлдөж байгаад зохиогч тайлар албан тоот ирүүлэх
- Шатны хонгилын шатны бариул зурагт тусгагдсаны дагуу гүйцэтгэх
- В1 давхар зохион байгуулалт өөрчлөгдсөнд зохиогч захиалагч нар тайлбар албан тоот ирүүлэх / хүчин чадал тодорхойлох/

ЛТЫН
г ашиглал
исс

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-уул дүүргийн 10 дугаар хороо, Иргэн Д.Хулангийн захиалгатай, зоорьтой 5 давхар 1 блок, 7 автомашины дулаан зогсоолтой, 19 айлын орон сууцны барилгыг ашиглалтанд оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч .................... (А.Мөнгөн)

902_041846
8314551 СБТ24866

Тэмдэглэл хөтөлсөн:
Захиалагч Иргэн .................... (Д.Хулан)

танд